



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/47

Хажуу шинэ үс

Газар ашиглуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл, Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.4.3 дахь заалт, 44 дугаар зүйлийн 44.1 дахь заалт, 44 дугаар зүйлийн 44.8 дахь заалт, Говь-Угтаал сумын иргэдийн төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн №25 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ШАНЖИН-ОРД ХХК уул уурхайн компанид хөрсний овоолгын зориулалтаар хавсралтад заасан газрыг зориулалтын дагуу ашиглуулсугай.

2. Газар ашиглах хугацааг 5 жилээр олгож, газрын хил заагийг тогтоож гэрээ байгуулан, гэрчилгээжүүлэн ажиллахыг газрын даамал /Б.Хорол/-д үүрэг болгосугай. 3. Газрыг зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр ашиглаж гэрээнд заасан үүргээ биелүүлж байхыг газар ашиглагч ШАНЖИН-ОРД ХХКомпаны захирал /Н. Цогцолмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

Газар ашиглуулах захирамжийн хавсралт

№	ГАЗАР АШИГЛАГЧ	РЕГИСТРИЙН ДУГААР	ГАЗРЫН ХЭМЖЭЭ	ГАЗРЫН БАЙРШИЛ
	Шанжин-Орд ХХК	5197325	133929.8 м2	3-р баг Хонгор “ Хараат ”